



Стратегийн төлөвлөгөө (2018-2022)

2018 оны 6-р сар

Танилцуулга

Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэг (МНЭММН) нь нийгмийн эрүүл мэндийн болон бусад мэргэжлийн сонирхсон хүмүүсийг нэгтгэсэн нийгмийн төлөө үйлчлэх, ашгийн төлөө бус төрийн бус байгууллага юм. Нийгэмлэгийн гишүүд нь нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн удирдлага, нийгмийн халамж, статистик, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүний эрх болон бусад чиглэлээр мэргэшсэн бөгөөд олон салбарт ажиллаж байна.

Нийгэмлэг нь 2002 онд байгуулагдсан цагаасаа хойш нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд тодорхой хувь нэмрээ оруулж, Монгол улсын засгийн газар болон олон улсын байгууллагуудтай хамтарч төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, үнэлгээ судалгаа хийх, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх, энэ чиглэлээрх хууль эрх зүйг таатай болгоход чиглэсэн ухуулга, нөлөөллийн ажлыг идэвхтэй явуулж байна.

МНЭММН нь 2010-2015 онд хэрэгжүүлсэн Стратегийн төлөвлөгөөндөө байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилтуудыг тодорхойлсон бөгөөд өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаанууд эдгээр зорилго зорилтод хүрэхэд чиглэсэн. Дараагийн 5 жилийн стратегийн төлөвлөгөөг боловсруулахын өмнө энэхүү стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийсэн.

Үнэлгээгээр дараах дүгнэлтүүд гарсан. Үүнд:

- Өнгөрсөн хугацаанд нийгмийн эрүүл мэндийн нотолгоонд тулгуурласан бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх ба эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийн мэдлэг, чадварыг тасралтгүй дээшлүүлэх стратегийн зорилтын хүрээнд түлхүү ажилласан байна.
- Нийгэмлэгийн санхүүжилтын 95.5%-г гадаад, дотоодын донор байгууллагын санхүүгийн дэмжлэг бүрдүүлж байгаа нь байгууллагын санхүүгийн эх үүсвэр донороос бүрэн хамааралтай байгааг харуулж байна.
- Нийгэмлэгийн байнга хамтарч ажиллаж буй байгууллагууд нь цөөн тооны төрийн байгууллагууд болон олон улсын төрийн бус байгууллагуудаар хязгаарлагдаж, ихэнх хамтарч ажилласан байгууллагуудтай тухайн төслийн хүрээнд нэг л удаа хамтарч ажилласан байсан.
- Нийгэмлэгээс зохион байгуулж буй эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэргийн шалгалт, төлбөртэй сургалт тогтмолжиж байгаагаас харахад цаашдаа үйл ажиллагааны энэ чиглэлээр хөрөнгө босгох боломж байгааг харуулж байна.
- Бүх гишүүдийн хурлаар стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэх, өөрчлөх, шинэчлэн батлах тухай дүрмийн заалт хэрэгжихгүй байна. Гишүүдийн идэвх сул, ирц бүрдэхгүй бол нийгэмлэгийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэх, өөрчлөн шинэчлэх, батлах ажил хийгдэхгүй байх нөхцөл үүссэн байна.

Нийгэмлэгийн дараагийн 5 жилийн стратегийн төлөвлөгөөг боловсруулахдаа дээр дурьдсан үнэлгээний дүгнэлт зөвлөмж, Нийгмийн эрүүл мэндийн дэлхийн нийгэмлэг болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргаж буй нийгмийн эрүүл мэндийн бодлогын зөвлөмж болон нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүдээс гаргасан санал зэрэгт үндэслэсэн.

Алсын хараа:

Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалахад мэргэжилтний чадавхыг нэгтгэн дайчилж, олон талт хамтын ажиллагааг сайжруулах замаар Монгол Улсад нийгмийн эрүүл мэндийн тогтвортой хөгжлийг дэмжих

Эрхэм зорилго:

МНЭММН-ийн төсөл хөтөлбөрийн удирдлага, хяналт үнэлгээ, судалгааны ажлын чадавхыг бэхжүүлснээр Монгол улсын нийгмийн эрүүл мэндийн бодлого тодорхойлоход хувь нэмрээ оруулдаг манлайлагч байгууллагуудын нэг болох

Стратегийн зорилтууд

1. Нотолгоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд идэвхтэй оролцох/нөлөөлөх
2. Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн мэдлэг, үр чадварыг тасралтгүй дээшлүүлэх
3. Гадаад, дотоодын байгууллагуудтай олон талт түншлэлийг хөгжүүлэх
4. Байгууллагын тогтвортой хөгжлийг хангах

Стратеги төлөвлөгөөний матриц

Зорилго	Стратеги	Хүрэх үр дүн	Гол түншлэгч байгууллага
<p>Зорилго 1. Нотолгоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд идэвхтэй оролцох/нөлөөлөх</p>	<p>1.1 Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын нийгмийн эрүүл мэндийн чиглэлийг хэрэгжүүлэхэд оролцох 1.2 Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн тогтолцооны чиглэлээрх бодлого, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, зөвлөмж гаргах 1.3 Нээлттэй засгийн түншлэл дэхь иргэний нийгмийн байгууллагын эвсэлд нэгдэж, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох 1.4 Нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг иргэдийн оролцоотойгоор тодорхойлж, ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх 1.5 Эрүүл мэндийн салбарт хэрэгцээт судалгаа хийх/оролцох</p>	<p>1. Жил бүр нэгээс доошгүй нийгмийн эрүүл мэндийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ. 2. Нийгмийн эрүүл мэндийн хоёроос доошгүй хууль, бодлогын баримт бичигт саналаа тусгана. 3. Хамгийн багадаа нэгээс хоёр тогтолцооны чиглэлээрх бодлого, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийнэ. 4. Нээлттэй засгийн түншлэл дэхь иргэний нийгмийн байгууллагуудын эвсэлд элсэнэ. 5. Ухуулга нөлөөллийн үр дүнд нэгээс доошгүй хууль, бодлого шийдвэрт өөрчлөлт оруулна. 6. Судалгаа, үнэлгээний зөвлөмжүүдээс хамгийн багадаа 25% нь цаашдын төлөвлөгөөнд тусгагдана.</p>	<p>ЭМЯ НЭМҮТ ОУБ</p>
<p>Зорилго 2. Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн мэдлэг, үр чадварыг тасралтгүй дээшлүүлэх</p>	<p>2.1 Нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудын сургалтын хэрэгцээг үнэлж, зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах 2.2 Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн болон эмнэлгийн удирдлагын чиглэлээр сургалт зохион байгуулах 2.3 Залцбургийн олон улсын семинарын эмч нарыг тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2.4 Эрдэм шинжилгээний хурал хамтран зохион байгуулах 2.5 Ментор, коучинг хөтөлбөр хэрэгжүүлэх</p>	<p>1. Жил бүр хоёроос доошгүй кредиттэй сургалтын эрхийг авна. 2. Батлагдсан төлөвлөгөөний жилд хоёроос дээш сургалт зохион байгуулна. 3. Хамгийн багадаа хоёр жилд нэг удаа эрдэм шинжилгээний хурал мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна. 4. Залцбургийн хөтөлбөрт жил бүр хамгийн багадаа 20 эмчийг хамруулна. 5. Залцбургийн хөтөлбөрт хамрагдсан эмч нарын дунд жилд нэгээс доошгүй томоохон үйл ажиллагаа зохион байгуулна. 6. Ментор коучинг хөтөлбөрт жил бүр 5-аас доошгүй мэргэжилтнүүдийг хамруулна.</p>	<p>ЭМЯ АШУУИС ЭМХТ Аймаг, нийслэлийн ЭМГ ОУБ</p>

<p>Зорилго 3. Гадаад, дотоодын байгууллагуудтай олон талт түншлэлийг хөгжүүлэх</p>	<p>3.1 Дэлхийн нийгмийн эрүүл мэндийн нийгэмлэгүүдийн холбооны (ДНЭМНХ) үйл ажиллагаанд идэвхтэй оролцох 3.2 Дэлхийн нийгмийн эрүүл мэндийн нийгэмлэгүүдийн холбооноос гаргасан бодлого (Global Charter)-ыг хэрэгжүүлэх 3.3 Эрүүл мэндийн салбарын төрийн болон төрийн бус байгууллагууд, академик болон мэргэжлийн нийгэмлэгүүдтэй нийгмийн эрүүл мэндийн асуудлаар хамтран ажиллах 3.4 Эрүүл мэндийг дэмжих болон эрүүл мэндийн бус чиглэлээр (тогтвортой болон ногоон хөгжил, аюулгүй ажлын байр г.м) ажиллаж буй бусад салбар, төсөл хөтөлбөр, ОУБ-ын үйл ажиллагааны эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хэрэгжилтэд хамтран ажиллах, харилцаагаа бэхжүүлэх 3.5 Бизнесийн байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх, хамтран ажиллах</p>	<p>1. Аливаа үйл ажиллагааг ДНЭМНХ-ны бодлого, үйл ажиллагаатай үялдуулж хийнэ. 2. ДНЭМНХ-оос ирсэн бүхий л бодлогын төсөлд санал өгч оролцоно. 3. Жил бүр эрүүл мэндийн багууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо нэмэгдэнэ. 4. Эрүүл мэндийн бус салбарт хамтарч ажилласан байдал жил бүр нэмэгдэнэ. 5. Бизнесийн байгууллагуудтай хамтарч ажиллах эхлэл тавигдана. 6. Салбарын томоохон хурал, уулзалт, зөвлөгөөнд жилд гурваас доошгүй удаа оролцоно.</p>	<p>ДНЭМНХ ЭМЯ ОУБ Академик байгууллагууд Мэргэжлийн нийгэмлэгүүд Эрүүл мэндийн болон бусад салбарын төрийн бус байгууллагууд Бизнесийн байгууллага</p>
<p>Зорилго 4. Байгууллагын тогтвортой хөгжлийг хангах</p>	<p>4.1 Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн мэндийн удирдлагын чиглэлээр суралцаж буй оюутнууд болон ажиллаж буй хүмүүст нийгэмлэгийн талаар мэдээлэл өгч, гишүүнчлэлийг нэмэгдүүлэх 4.2 Нийгэмлэгийн гишүүдийг мэргэшил, сонирхлын дагуу ажлын хэсэг, багуудад хуваах 4.3 Нийгэмлэгийн гишүүдийн дунд менторийн хөтөлбөр хэрэгжүүлж, залуу гишүүдийн чадавхыг бэхжүүлэх 4.4 Нийгэмлэгийн гишүүдийг хамруулсан үйл ажиллагаа зохион байгуулах</p>	<p>1. Нийгэмлэгийн гишүүдийн тоо жил бүр 10-20% нэмэгдэнэ. 2. Жил бүр гишүүдийн дунд нэгээс доошгүй үйл ажиллагаа зохион байгуулна. 3. Менторийн хөтөлбөрт жил бүр 10-аас доошгүй гишүүдийг хамруулна. 4. Нийгэмлэгийн үндсэн ажилтны тоог жил бүр тогтвортой ажиллуулна. 5. Нийгэмлэгүүдийн ажилтан бүр жилд хоёроос доошгүй хөгжүүлэх сургалтад хамруулна. 6. Ажилтан бүр гадаад, дотоодын хурал, зөвлөгөөнд хамгийн багадаа хоёр удаа оролцоно. 7. Хяналт үнэлгээний загвартай болно.</p>	<p>Дотоодын болон ОУБ IT байгууллага Нийгэмлэгийн гишүүд Их сургуулиуд Эрүүл мэндийн байгууллага</p>

	<p>4.5 Байгууллагын хөтөлбөрийн мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлж, чадавхжуулах</p> <p>4.6 Байгууллагын дотоод нөөц бололцоо, шинээр төсөл хөтөлбөр боловсруулах замаар санхүүгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх</p> <p>4.7 Байгууллагын брэнд, хийгдэж буй үйл ажиллагааг олон нийтийн сүлжээ, харилцааны сувгуудаар тогтмол сурталчлах</p> <p>4.8 Вeбсайтыг монгол, англи хэл дээр шинэчлэх</p> <p>4.9 Хяналт үнэлгээний загварыг бий болгох</p>		
--	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	--